

ТАНИЛЦУУЛГА

Иргэд харилцан зорчих нөхцөлийг хөнгөвчлөх зорилгоор Сингапурын ГЯЯ 1990 онд албан ёсоор саналаа өгсөн болно. Уг саналын дагуу хоёр долоо хоногийн хугацаагаар Монголд ирэх Сингапурын жуулчид, ажил хэргийн хүмүүст визгүй зорчиж байх зөвшөөрлийг хүссэн юм. /Сингапурын 826/,90, 148/90 тоот нот/

Манай тал энэхүү саналыг зарчмын хувьд хүлээн зөвшөөрсөн бөгөөд гагцхүү эл асуудлын талаар ямар нэгэн тохиролцоо бий болгох нь зүйтэй гэж үзсэний улмаас нот солилцон мөрдөж болох юм гэсэн хариу өгсөн болно.

Сингапурт очих аль ч улсын иргэнийг хоёр долоо хоног хүртэл хугацаагаар визгүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хуультай бөгөөд энэ тухайгаа дэлхий нийтэд зарлажээ. Монголын иргэдийн хувьд ч энэ хууль адилхан үйлчлэх болсон бөгөөд харин монголын тал харилцан адил байх зарчмыг баримтлан Сингапурын иргэдийн хувьд мөн хугацаагаар Монголд визгүй зорчихыг зөвшөөрсөн шийдвэр гаргаж, тэр тухайгаа Сингапурын талд мэдэгдэх асуудал үлдээд байгаа юм. Мөн Сингапурын тал бусад бүх улсын иргэдийг ийнхүү визгүй нэвтрүүлж өөрийн иргэдийг адилхан илгээж байхаар тохиролцон зарласан тул зөвхөн Монгол Улстай уг асуудлаар тусгайлсан хэлэлцээр байгуулах, нот солилцох шаардлагагүй гэж үзэж байгаагаа мэдэгдэв.

Иймд манай улс дэлхийн хамтын нийгэмлэгийн гишүүний хувьд Сингапурын саналыг зөвшөөрөх нь зүйтэй байна.

КОНСУЛЫН ГАЗАР

№ КГ-498

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Сингапур Улсын Гадаад явдлын яаманд гүн хүндэтгэлээ илэрхийлж, танай энэ оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 826/90 тоот нотыг хүлээн нотлох ялдамд тус хоёр улсын хооронд адил байх үндсэн дээр визийн асуудлаар дараах журмыг тогтоох саналтай байгааг толилуулах завшаан тохиолдов. Үүнд:

1. Аль нэг талын дипломат буюу албан паспорттай иргэн нөгөө талын нутаг дэвсгэрт түүний визгүйгээр орж, гарч, дамжин өнгөрч болно.
2. Бусад тохиолдолд аль нэг талын иргэн нөгөө талын нутаг дэвсгэрт зорчихдоо түүний визийг авах болно.
3. Аль нэг тал нөгөө талдаа бичгээр мэдэгдэх замаар энэхүү тохиролцоог хэзээ ч хүчингүй болгож болно. Энэ тухайгаа аль нэг тал бичгээр мэдэгдмэгц уг тохиролцоо хүчингүй болно.

БҮГД НАЙРАМДАХ СИНГАПУР УЛСЫН
ГАДААД ЯВДЛЫН ЯАМАНД
Сингапур

2.

Хэрэв Сингапурын тал энэ саналыг хүлээн зөвшөөрвөл хоёр тал тохиролцсон журмыг нот солилцон мөрдөж болно гэж үзэж байна.

Энэ ялдамд Бүгд найрамдах Монгол Ард Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Сингапур Улсын Гадаад явдлын яаманд гүн хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

Улаанбаатар хот,
1990 оны 12 дугаар сарын 22-ны өдөр

БНМАУ
ГАДААД ЯВДЛЫН ЯАМ

1990 оны 12 дугаар

Дугаар КГ-520

Улаанбаатар хот

Утас : 24336

ЭЛЧИН САЙД НӨХӨР Д. ЁНДОН ТАНАА

Зарим зүйл мэдээлэх тухай

1. Албан ажлаар зорчих иргэдийг 14 хоногийн дотор визгүйгээр хил нэвтрүүлэх, хувийн хэргээр зорчих иргэд урьдчилан виз авч байх тухай саналыг Сингапурын ЭСЯ-нд нот дагалдуулан мэдэгдэхийг танай а/б-260 тоотын хариу болгон энэ оны эхээр төвөөс хүргүүлсэн. Сингапурын ЭСЯ-нд албан ёсоор мэдэгдээгүй байгаа бол хавсралт нотыг даруй уламжилна уу.

2. Атташе Д.Баярсайхан 1991 оны хоёрдугаар сараас эхлэн гадаадын иргэдэд олгох визэнд гарын үсэг зурж болно. Гарын үсгийн загваруудыг манай хилийн боомт, холбогдох газруудад хүгүүлдэг тул 9 хувь зурж ирүүлдэг заавар хүчинтэй байгаа. Танай А/б-188 тоотоор дагалдуулан ирүүлсэн загвар 1 хувь тул хувиан олшруулах журамгүйгээс ашиглах боломжгүй болов. Иймд манай гадаад дахь дипломат төлөөлөгчийн бусад газруудын ажилтнуудын нэгэн адилаар нөхөр Д.Баярсайхан гарын үсгээ 9 хувь зурж ирүүлэхийг хүсч байгааг ойлгуулна уу.

Хавсралт Гадаад харилцааны яамны КГ-498 тоот нот.

ГАЗРЫН ДАРГА

/Г. ЭРДЭНЭ/

БНМАУ
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

1991 оны 3 сарын 29

¹ а/б-104

Токио хот

ГХЯ-НЫ КОНСУЛЫН ГАЗРЫН ДАРГА
Г.ЭРДЭНЭ ТАНАА

Нот хүргүүлэх тухай

Албан ёсны хэлэлцээр байгуулахгүйгээр, харилцан адил байх үндсэн дээр Монголд хоёр долоо хоногоор очих Сингапурын иргэдэд визгүй зорчих эрх олгохыг хүссэн тухай Сингапурын ГЯЯ-ны нотыг үүгээр хүргүүлэн хүлээн авч танилцан уг асуудлыг шийдвэрлэж хариу мэдэгдэхийг хүсье.

ЭЛЧИН САЙД

/Д.ЁНДОН/

БНМАУ

ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

ТОКИО ДАХЬ ЭЛЧИН САЙДЫН ЯАМАНД

¹ КГ/139

Сингапурын саналын тухай

Огноо 1991.04.11
Улаанбаатар хот-11
Утас: 24336

Хүчин төгөлдөр үндэсний паспорт бүхий хоёр улсын иргэд хоёр долоо хоногийн хугацаатайгаар харилцан визгүй зорчиж байх журам тогтоохыг Монголын тал зарчимын хувьд зөвшөөрч байна.

Танай улсад тогтсон журам, дүрмийн дагуу уг асуудлын талаар албан ёсны тохиролцоо байгуулах нь шаардлагатай юм. Энэхүү тохиролцоог нот солилцон мөрдөж болно гэж манай тал үзэж байна.

Дээр дурдсан зүйлийг Сингапурын Элчин сайдын яаманд мэдэгдэж хариу өгнө үү.

КОНСУЛЫН ГАЗРЫН ДАРГА

/Г.ЭРДЭНЭ/

БНМАУ
ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

1991 оны 06 сарын 26

¹ а/б-214

Токио хот

ГАДААД ХАРИЛЦААНЫ ТЭРГҮҮН ДЭД САЙД
Ж. ЧОЙНХОР ТАНАА

Танай КГ-139 тоот
бичгийн хариу

Сингапурт очих аль ч орны иргэнийг хоёр долоо хоног хүртэл хугацаагаар визгүй нэвтрүүлэхийг зөвшөөрсөн хуультай бөгөөд энэ тухайгаа дэлхий нийтэд зарлажээ. Монголын иргэдийн хувьд ч энэ хууль адилхан үйлчлэх болсон бөгөөд одоо гагцхүү Монголын тал харилцан адил байх зарчмыг баримтлан Сингапурын иргэдийн хувьд мөн хугацаагаар Монголд визгүй зорчих зөвшөөрсөн шийдвэр гаргаж, тэр тухайгаа Сингапурын талд мэдэгдэх асуудал үлдээд байгаа юм.

Сингапурын тал бусад бүх улсын иргэдийг ийнхүү визгүй нэвтрүүлж өөрийн иргэдийг адилхан илгээж байхаар тохиролцон зарласан тул зөвхөн Монгол улстай уг асуудлаар тусгайлан хэлэлцээр байгуулах, нот солилцох шаардлагагүй гэж байгаагаа дахин нотолж мэдэгдэв.

Иймд манай улс дэлхий нийтийн нийгэмлэгийн гишүүний хувьд Сингапурын саналыг элдэв тайлбаргүй зөвшөөрч, заавал албан бичиг солилцох гэхгүй байх нь зүйтэй байна.

Манай тал Сингапурын иргэдийг Монголд визгүй зорчихыг зөвшөөрсөн шийдвэр гаргаад тэр тухайгаа Сингапурын талд мэдэгдэх журмаар асуудлыг хялбар шийдвэрлэж болох байна. Ийм чиглэлээр асуудлыг хянан үзэж хариу өгөхийг хүсье.

ЭЛЧИН САЙД

/Д. ЁНДОН/

**БНМАУ
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ**

1991 оны 10 сарын 18

¹ КГ-403

Улаанбаатар хот
Утас 24336

ХИЛИЙН ЦЭРГИЙН ГАЗАРТ

БНМАУ, Сингапур улсын иргэд хоёр долоо хоногийн хугацаанд харилцан визгүй зорчиж байх болсныг мэдэгдэж байна. Иймд нутаг дэвсгэрт визгүйгээр нэвтрүүлж байхыг холбогдох байгууллагуудад мэдэгдэнэ үү. Энэ журмыг 10 дугаар сарын 1-нээс эхэлж мөрдвөл зохино.

КОНСУЛЫН ГАЗРЫН ДАРГА

/Г. ЭРДЭНЭ/